

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 2 сарын 9 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.10 дахь заалт, Ногдол ашгийн журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны цэвэр ашиг болох 3,705,620,626.44 төгрөгөөс компанийн хувьцаа эзэмшигчдэд 2,200,000,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.
2. Нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1.10 /нэг төгрөг арван мөнгө/ төгрөгөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр, ногдол ашиг төлөх сүүлийн өдрийг 2025 оны 4-р сарын 30-ны өдрөөр тус тус тогтоосугай.
4. Ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг компанийн данснаас хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай.
5. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал /Б.Бадамцэцэг/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.Чинзориг

Ч.ЧИНЗОРИГ